

**БАТЛАВ:**

**МЭДЭЭЛЛИЙН “МОНЦАМЭ”  
АГЕНТЛАГИЙН ДАРГА**



**Б.ГАНЧИМЭГ**

**МЭДЭЭЛЛИЙН МОНЦАМЭ АГЕНТЛАГ**

**ГЭРЭЛ ЗУРГИЙН ЦААС, БИЧГИЙН ЦААС, ХЭВЛЭХИЙН ЦААС НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

**Тендерийн нэр: “ГЭРЭЛ ЗУРГИЙН ЦААС, БИЧГИЙН ЦААС, ХЭВЛЭХИЙН ЦААС  
ХУДАЛДАН АВАХ”**

**Тендер шалгаруулалтын дугаар: МОНЦАМЭ/202004006**

Улаанбаатар хот  
2020 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.04.10

**Мэдээллийн МОНЦАМЭ агентлаг** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “**гэрэл зургийн цаас, бичгийн цаас, хэвлэхийн цаас**”-ийг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул ([tender.gov.mn](http://tender.gov.mn)) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө **₮50,000** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Үнийн саналыг **2020 оны 04 дүгээр сарын 17 өдрийн 14 цаг 00 минутаас өмнө** худалдан авах ажиллагааны цахим систем ашиглан [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04 дүгээр сарын 17 өдрийн 14 цаг 30 минут**-д нээнэ.

Дотоодын давуу эрх **тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Чингэлтэй дүүрэг, Б.Жигжиджавын гудамж-8,  
Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн байр,  
4 давхарт, 407 тоот Б.Пүрэвсанжаа 51-263893**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

	Гурав. <b>ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ</b>
<b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>
<b>ТӨӨЗ 1.1</b>	<p><b>Ерөнхий шалгуур үзүүлэлт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар</li> <li>- Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <b>Сүүлийн 2 жил /2018, 2019 он/-ийн аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг тендерийн материалдаа хавсарган ирүүлнэ.</b></li> <li>- Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт</li> <li>- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт</li> <li>- Харилцагч банкны тодорхойлолт /Хугацаа хэтэрсэн зээлийн төлбөр төлбөргүй байх/</li> <li>- НӨАТ төлөгчийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар</li> <li>- Татварын цахим тодорхойлолт /Тендер нээсэн өдрийн байдлаар татварт өр төлбөргүй байх ба тендерийн нээлт хийх өдөр тодорхойлолтыг цахим сайтаас авна./</li> <li>- Нийлүүлэх гэрэл зургийн цаас, хэвлэхийн цаас, бичгийн цаасны техникийн үзүүлэлтийг ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан шаардлага тус бүрээр харьцуулж ирүүлэх</li> <li>- Баталгаат хугацаа 1 жилийг баталсан албан бичиг ирүүлнэ</li> </ul> <p><b>Багц 1, Багц 3-т оролцогч нь:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Гүйцэтгэгчээр ажилласан байх туршлага: Сүүлийн 2 жилийн хугацаанд буюу 2018, 2019 онуудад тус бүр ижил төстэй барааг нийлүүлсэн туршлагатай байх бөгөөд гэрээний хуулбараар баталгаажуулан ирүүлнэ.</li> </ul> <p><b>Багц 2-т оролцогч нь:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Цаас хадгалах стандартын шаардлага хангасан агуулахтай шаардлагатай ба зургийг хавсарган ирүүлнэ. Мөн сүүлийн 10 жилийн хугацаанд буюу 2000-2019 онуудад тус бүр ижил төстэй барааг нийлүүлсэн туршлагатай байх бөгөөд гэрээний хуулбараар баталгаажуулан ирүүлнэ.</li> </ul>
<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Цахим тендер тул үнийн саналыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар ирүүлнэ.</p> <p>Огноо: <b>2020 оны 04 дүгээр сарын 17 өдөр</b></p> <p>Цаг: <b>14 цаг 00 минут</b></p>

<b>ТӨӨЗ 2.1</b>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Чингэлтэй дүүрэг, Б.Жигжиджавын гудамж-8, Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн байр</b></p> <p>Давхар болон ерөөний дугаар: <b>1 давхарт, 103 тоот</b></p> <p>Огноо: <b>2020 оны 04 дүгээр сарын 17 өдөр</b></p> <p>Цаг: <b>14 цаг 30 минут</b></p>
<b>ТӨӨЗ 2.3</b>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. <b><i>[Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор ТШӨХ-д заасан бүх баримт бичгийг жагсаан бичих]</i></b></li> <li>2. ...</li> <li>3. ...</li> </ol>
<b>ТӨӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p>Багц 1: Гэрэл зургийн цаас нийлүүлэх  Багц 2: Хэвлэхийн цаас нийлүүлэх  Багц 3: Бичгийн цаас нийлүүлэх</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

№	Барааны нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Ерөнхий шаардлага	
<b>БАГЦ 1 - ГЭРЭЛ ЗУРГИЙН ЦААС</b>					
1	Матт цаас /Рулонтой/	ширхэг	20	Өргөн 20.3см, Урт 86м, Lucky цаастай дүйцэхүйц болон түүнээс илүү	
2	Матт цаас /Рулонтой/	ширхэг	4	Өргөн 12.7см, Урт 183м, Lucky цаастай дүйцэхүйц болон түүнээс илүү	
<b>БАГЦ 2 - ХЭВЛЭХИЙН ЦААС</b>					
3	Номын хөнгөн шар цаас /70 гр/	ширхэг	98000	A0 хэвлэлийн форматтай 889mm X 1194mm -н хэмжээтэй	
4	Шохойтой цаас /105 гр/	ширхэг	4500		
5	Шохойтой цаас /128 гр/	ширхэг	500		
6	Шохойтой цаас /157 гр/	ширхэг	250		
7	Шохойтой цаас /200 гр /	ширхэг	1000		
8	Шохойтой цаас /250 гр/	ширхэг	125		
9	Шохойтой цаас /300 гр/	ширхэг	100		
10	Офсет цаас /100 гр/	ширхэг	250		
11	Матт цаас /80 гр/	ширхэг	6500		
12	Матт цаас /250 гр/	ширхэг	125		
13	Матт цаас /200 гр/	ширхэг	125		
14	Матт цаас /300 гр/	ширхэг	100		
15	Фото цаас /Рулонтой/	рулон	2		Өргөн 60-61см, Урт 30м болон түүнээс дээш
16	Даавуун цаас /Рулонтой/	рулон	2		
<b>БАГЦ 3 – БИЧГИЙН ЦААС</b>					
11	Цаас	боодол	20	A3 хэмжээтэй, 70-75 гр/м <sup>2</sup> нятгалтай, боодолдоо 500 ширхэгтэй	
12	Бичгийн цаас	боодол	52	A4 хэмжээтэй, 70 гр/м <sup>2</sup> болон түүнээс дээш, боодолдоо 500 ширхэгтэй	
13	Инк цаас /250 гр/	боодол	15	A4 хэмжээтэй, 50 ширхэгтэй	
14	Фото инк цаас /250 гр/	боодол	15		
15	Матт цаас /250 гр/	боодол	5		
16	Алтан шаргал инк цаас	боодол	10		

2. **Стандарт:** Нийлүүлэгчийн бүх бараа нь шинэ, ашиглагдаагүй, сүүлийн үеийн хандлагыг хангасан байна. Нийлүүлэх бараа нь стандартад нийцсэн байх. Барааг захиалагч буюу захиалагчийн төлөөлөгч шалгаж туршина.

3. **Баглаа, боодол:** Өргөж зөөхөд тохиромжтой байдлаар багцалж бооно.

4. **Бараа хүргэх газар:** Чингэлтэй дүүрэг, Б.Жигжиджавын гудамж-8, Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн байр

5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

#### БАГЦ 1 - ГЭРЭЛ ЗУРГИЙН ЦААС

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Матт цаас /Рулонтой/	Матт цаас /Рулонтой/	20	ширхэг	Мэдээллийн МОНЦАМА агентлаг	2020.05.01 Захиалгын хэмжээгээр жилд хэд хэдэн удаа	2020.12.31 Захиалгын хэмжээгээр жилд хэд хэдэн удаа	
Матт цаас /Рулонтой/	Матт цаас /Рулонтой/	4	ширхэг				

#### БАГЦ 2 - ХЭВЛЭХИЙН ЦААС

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Номын хөнгөн шар цаас /70 гр/	Номын хөнгөн шар цаас /70 гр/	98000	ширхэг	Мэдээллийн МОНЦАМА агентлаг	2020.05.01 Захиалгын хэмжээгээр жилд хэд хэдэн удаа	2020.12.31 Захиалгын хэмжээгээр жилд хэд хэдэн удаа	
Шохойтой цаас /105 гр/	Шохойтой цаас /105 гр/	4500	ширхэг				
Шохойтой цаас /128 гр/	Шохойтой цаас /128 гр/	500	ширхэг				
Шохойтой цаас /157 гр/	Шохойтой цаас /157 гр/	250	ширхэг				



Шохойтой цаас /200 гр /	Шохойтой цаас /200 гр /	1000	ширхэг				
Шохойтой цаас /250 гр/	Шохойтой цаас /250 гр/	125	ширхэг				
Шохойтой цаас /300 гр/	Шохойтой цаас /300 гр/	100	ширхэг				
Офсет цаас /100 гр/	Офсет цаас /100 гр/	250	ширхэг				
Матт цаас /80 гр/	Матт цаас /80 гр/	6500	ширхэг				
Матт цаас /250 гр/	Матт цаас /250 гр/	125	ширхэг				
Матт цаас /200 гр/	Матт цаас /200 гр/	125	ширхэг				
Матт цаас /300 гр/	Матт цаас /300 гр/	100	ширхэг				
Фото цаас /Рулонтой/	Фото цаас /Рулонтой/	2	ширхэг				
Даавуун цаас /Рулонтой/	Даавуун цаас /Рулонтой/	2	ширхэг				

### БАГЦ 3 – БИЧГИЙН ЦААС

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Цаас	Цаас	боодол	20	Мэдээллийн МОНЦАМА агентлаг	2020.05.01 Захиалгын хэмжээгээр жилд хэд хэдэн удаа	2020.12.31 Захиалгын хэмжээгээр жилд хэд хэдэн удаа	
Бичгийн цаас	Бичгийн цаас	боодол	52				
Инк цаас /250 гр/	Инк цаас /250 гр/	боодол	15				
Фото инк цаас /250 гр/	Фото инк цаас /250 гр/	боодол	15				
Матт цаас /250 гр/	Матт цаас /250 гр/	боодол	5				
Алтан шаргал инк цаас	Алтан шаргал инк цаас	боодол	10				

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

Мэдээллийн **МОНЦАМЭ агентлагийн** дарга Б.Ганчимэг танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>3</b> хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li><li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ol> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]</p>   |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Барааг хүлээн авсан гүйцэтгэлээр нэхэмжлэхийн дагуу гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p>  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</b>                              | <p>9.1. Алданги оногдуулах хувь: <b>0.5</b></p> <p>Алдангийн нийт дүн: <b>5</b></p>  |

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>1</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*